



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БӨА-2026/132/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Өлгий хот

2026 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын,
дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 7024229524 Цахим хаяг: aigul@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 702422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн захирал: М.Нурболат
Утас: 70007275 Цахим хаяг: lightanddelightaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

**АЛТАЙ СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Х.ЖАНБОТА ТАНАА**

2026.02.26 № 235
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дүгээр сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Алтай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Алтай сумын хүүхдийн цэцэрлэг нь 2025 онд 1,697.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 1,684.1 сая төгрөг зарцуулж, 99.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

832605000260

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>296,495,910.74</u>	<u>113,497,021.20</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	191,894,076.00	4,842,926.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	191,894,076.00	4,842,926.00
3121	Төгрөг	191,894,076.00	4,842,926.00
31211	Төрийн сангийн харилцах	191,894,076.00	4,842,926.00
33	АВЛАГА	-	4,227,125.46
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	3,765,525.46
335	Бусад авлага	-	461,600.00
3351	Байгууллагаас авах авлага	-	461,600.00
35	БАРАА МАТЕРИАЛ	104,601,834.74	104,426,969.74
351	Түүхий эд материал	101,100.00	79,100.00
35130	Эм боох материал	101,100.00	79,100.00
354	Хангамжийн материал	104,500,734.74	104,347,869.74
35410	Бичиг хэргийн материал	1,709,450.00	3,412,950.00
35420	Аж ахуйн материал	34,154,808.11	35,223,158.11
35440	Түлш, шатах тослох материал	5,048,306.50	2,115,556.50
35460	Хүнсний материал	5,453,079.89	3,284,414.89
35470	Бусад хангамжийн материал	58,135,090.24	60,311,790.24
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>850,236,638.91</u>	<u>809,109,980.91</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	850,236,638.91	809,109,980.91
392	Биет хөрөнгө	843,708,162.06	802,878,012.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	877,775,623.75	877,775,623.75
39202	Хуримтлагдсан элэгдэл	(137,109,779.52)	(162,312,838.68)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	78,873,387.00	69,597,300.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(43,109,915.30)	(43,629,161.30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	69,750,485.03	52,577,185.45
39208	Хуримтлагдсан элэгдэл	(37,282,517.06)	(20,959,866.02)
39214	Бусад үндсэн хөрөнгө	47,982,626.00	41,102,626.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(18,141,997.84)	(16,243,107.04)
39217	Ном	4,970,250.00	4,970,250.00
393	Биет бус хөрөнгө	6,528,476.85	6,231,968.75
39301	Програм хангамж	1,606,739.00	1,606,739.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(628,262.15)	(924,770.25)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,550,000.00	5,550,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,146,732,549.65</u>	<u>922,607,002.11</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>29,032,150.31</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	29,032,150.31
413	Өглөг	-	29,032,150.31
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	27,151,350.31
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,880,800.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,146,732,549.65</u>	<u>893,574,851.80</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,146,732,549.65	893,574,851.80
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	71,266,177.87	71,266,177.87
512	Хуримтлагдсан үр дүн	791,461,605.07	538,303,907.22
51210	Өмнөх үеийн үр дүн	791,461,605.07	791,461,605.07

Алтай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51220	Тайлант үеийн үр дүн	-	(253,157,697.85)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	284,004,766.71	284,004,766.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,146,732,549.65	922,607,002.11

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,450,768,983.00	1,500,790,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,038,583.00	3,746,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,038,583.00	3,746,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	7,552,333.00	3,400,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	8,486,250.00	
120009	Бусад орлого	-	346,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,434,730,400.00	1,497,044,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,324,465,500.00	1,400,197,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,324,465,500.00	1,400,197,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	110,264,900.00	96,847,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	110,264,900.00	96,847,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,456,617,520.27	1,753,948,097.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,456,617,520.27	1,753,948,097.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,456,617,520.27	1,753,947,297.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,029,532,983.91	1,322,273,026.64
210101	Үндсэн цалин	747,154,514.91	924,032,972.81
210102	Нэмэгдэл	266,304,669.00	356,008,443.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	12,390,000.00
210104	Урамшуулал	16,073,800.00	29,841,610.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	130,424,726.09	167,166,998.21
210201	Тэтгэврийн даатгал	89,253,465.14	114,512,891.23
210202	Тэтгэмжийн даатгал	10,500,407.63	13,472,104.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,283,932.10	6,927,767.10
210204	Ажилгүйдлийн даатгал	4,864,072.72	6,450,847.31
210205	Эрүүл мэндийн даатгал	20,522,848.50	25,803,387.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,910,936.00	101,660,050.00
210301	Гэрэл, цахилгаан	3,018,500.00	4,528,000.00
210302	Түлш, халаалт	89,892,436.00	66,657,250.00
210304	Байрны түрээс	9,000,000.00	30,474,800.00
2105	Нормативт зардал	119,289,300.00	91,674,215.00
210502	Хоол, хүнс	119,289,300.00	91,674,215.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	-
210604	Урсгал засвар	500,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,919,600.00	4,218,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,919,600.00	4,218,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	73,039,974.27	66,954,208.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,597,100.00	11,055,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,968,600.00	6,571,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,474,274.27	49,326,658.00

Алтай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	800.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(5,848,537.27)</u>	<u>(253,157,697.85)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(5,848,537.27)</u>	<u>(253,157,697.85)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,434,730,400.00	1,497,390,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	346,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	346,000.00
120009	Бусад орлого	-	346,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,434,730,400.00	1,497,044,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,324,465,500.00	1,400,197,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,324,465,500.00	1,400,197,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	110,264,900.00	96,847,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	110,264,900.00	96,847,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,416,732,010.00	1,684,441,550.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,416,732,010.00	1,684,441,550.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,416,732,010.00	1,684,440,750.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,029,958,381.91	1,303,930,900.00
210101	Үндсэн цалин	731,898,792.00	800,208,194.70
210102	Нэмэгдэл	281,985,789.00	452,189,805.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	12,170,000.00
210104	Урамшуулал	16,073,800.91	39,362,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,999,328.09	162,123,300.00
210201	Тэтгэврийн даатгал	88,719,339.78	109,966,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,434,562.81	13,039,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,252,595.30	6,519,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,128,343.10	6,519,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,464,487.10	26,078,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,764,900.00	96,846,500.00
210301	Гэрэл, цахилгаан	3,018,500.00	4,528,000.00
210302	Түлш, халаалт	94,746,400.00	63,724,500.00
210304	Байрны түрээс	12,000,000.00	28,594,000.00
2105	Нормативт зардал	115,574,700.00	89,505,550.00
210502	Хоол, хүнс	115,574,700.00	89,505,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	-
210604	Урсгал засвар	500,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,919,800.00	4,705,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,919,800.00	4,705,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,014,900.00	27,329,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,448,000.00	19,278,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,566,900.00	8,050,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	800.00

Алтай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	800.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	17,998,390.00	(187,051,150.00)
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,960,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,960,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	7,960,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,960,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(7,960,000.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	10,038,390.00	(187,051,150.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	181,855,686.00	191,894,076.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	191,894,076.00	4,842,926.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	71,266,177.87	284,004,766.71	797,310,142.34	1,152,581,086.92
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	71,266,177.87	284,004,766.71	797,310,142.34	1,152,581,086.92
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(5,848,537.27)	(5,848,537.27)
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	71,266,177.87	284,004,766.71	791,461,605.07	1,146,732,549.65
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	71,266,177.87	284,004,766.71	791,461,605.07	1,146,732,549.65
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	71,266,177.87	284,004,766.71	791,461,605.07	1,146,732,549.65
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(253,157,697.85)	(253,157,697.85)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	71,266,177.87	284,004,766.71	538,303,907.22	893,574,851.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,697,885,300.00	1,684,094,750.00	13,790,550.00	99.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,697,885,300.00	1,684,094,750.00	13,790,550.00	99.2

Алтай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,697,885,300.00	1,684,094,750.00	13,790,550.00	99.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,306,861,500.00	1,303,930,900.00	2,930,600.00	99.8
210101	Үндсэн цалин	799,699,300.00	800,208,194.70	(508,894.70)	100.1
210102	Нэмэгдэл	464,868,700.00	452,189,805.30	12,678,894.70	97.3
210104	Урамшуулал	42,293,500.00	39,362,900.00	2,930,600.00	93.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	162,123,300.00	162,123,300.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	109,966,100.00	109,966,100.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	13,039,400.00	13,039,400.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,519,600.00	6,519,600.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	6,519,600.00	6,519,600.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	26,078,600.00	26,078,600.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,528,000.00	96,846,500.00	8,681,500.00	91.8
210301	Гэрэл, цахилгаан	4,528,000.00	4,528,000.00	-	100.0
210302	Түлш, халаалт	65,000,000.00	63,724,500.00	1,275,500.00	98.0
210304	Байрны түрээс	36,000,000.00	28,594,000.00	7,406,000.00	79.4
2105	Нормативт зардал	90,337,200.00	89,505,550.00	831,650.00	99.1
210502	Хоол, хүнс	90,337,200.00	89,505,550.00	831,650.00	99.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	-	1,000,000.00	-
210604	Урсгал засвар	1,000,000.00	-	1,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,705,400.00	4,359,400.00	346,000.00	92.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,705,400.00	4,359,400.00	346,000.00	92.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,329,900.00	27,329,100.00	800.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,278,800.00	19,278,800.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,051,100.00	8,050,300.00	800.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,697,885,300.00	1,497,043,600.00	200,841,700.00	88.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,401,028,700.00	1,400,197,100.00	831,600.00	99.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,401,028,700.00	1,400,197,100.00	831,600.00	99.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	106,528,000.00	96,846,500.00	9,681,500.00	90.9
132001	Орон нутгийн төсвөөс	106,528,000.00	96,846,500.00	9,681,500.00	90.9
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	190,328,600.00	-	190,328,600.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	190,328,600.00	-	190,328,600.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		191,894,076.00		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,842,926.00		-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	57	61	-	107.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	28	28	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	28	32	4	114.3

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт 18,940.4 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант хугацаанд үндсэн хөрөнгөд нийт 7,964.1 мянган төгрөгийн элэгдлийг тооцоогүй байна.	1	7,964.1	1	7,964.1	-	-	-	-	-	-	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөний дүнг 10,514.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, орон нутгийн төвлөрүүлэн шилжүүлэг 0.8 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд цэвэрлэж тусгаагүй байна.	1	10,514.8	-	-	1	10,514.8	-	-	-	-	-	-
Юнивишн ХХК-д урьдчилж төлсөн интернэтийн төлбөр болох 461.6 мянган төгрөгийг авлага үүсгээгүй зардлаар бүртгэсэн байна.	1	461.6	-	-	1	461.6	-	-	-	-	-	-
ДҮН	3	18,940.4	1	7,964.1	2	10,976.4	-	-	-	-	-	-

Аудитаар нийт 9,383.4 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 7,978.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1,405.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Жилийн эцэст татвар, НД-ын хэлтэстэй тооцоо нийлсэн боловч нийт 1,405.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	1,405.1	-	-	-	-	1	1,405.1	-	-	-	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Тайлант онд Нуртөре ХХК-тай байгуулсан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээнд төлбөрийн нөхцөлийг тодорхой тусгаагүй, дулаанаар хангагдах эзлэхүүн болон зохицуулах зөвлөлийн холбогдох тогтоолыг үндэслэн тооцоход тайлант хугацаанд 35,971,749.66 төгрөгийн төлбөр төлөх ёстой байсан боловч 43,950,500 төгрөгийг төлж, 7,978,750.34 төгрөгийн илүү төлөлт үүссэн, харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй, завсрын аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Гэвч уг илүү төлөлтийг авлага үүсгэн бүртгээгүй, тайлант хугацааны зардалд шууд тусгасан нь нягтлан бодох бүртгэлийн холбогдох журам, зааврыг зөрчсөн байна	1	7,978.3	-	-	1	7,978.3	-	-	-	-	-	-
ДҮН	2	9,383.4	-	-	1	7,978.3	1	1,405.1	-	-	-	-

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

мянган төгрөг

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 81.6 хув, хугацаа хоцролтын хэрэгжилт 62.9 хувьтай байна.	1	64,021.2	-	-	-	-	1	64,021.2
ДҮН	1	64,021.2	-	-	-	-	1	64,021.2